***Б.Амгаланбаяр*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, ахмад*

# ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

***Хураангуй.*** *Энэхүү өгүүлэлд цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, сайжруулах арга замыг бий болгох чиглэлээр санал дэвшүүллээ.*

***Түлхүүр*** *үг. Цагдан хорих байр аюулгүй байдал, түүний бүрэлдэхүүн хэсэг болох алба хаагчийн аюулгүй байдал, хоригдогсдын аюулгүй байдлыг хангах асуудал*

Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль’”-нд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний хэргийн талаархи Шийдвэр гүйцэтгэх газар, эрүүгийн хэргийн талаархи Тогтоол гүйцэтгэх газар гэсэн үндсэн бүтэцтэйгээр чиг үүргээ хэрэгжүүлэхээр хуваан авч үздэг.

Эндээс хорих байгууллага нь цагдан хорих үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад сэжигтэн, яллагдагчийг тусгайлсан стандарт бүхий орчинд нийгмээс тусгаарлан хорих, тэдгээрийн зүгээс дахин гэмт хэрэг үйлдэх, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх[1] [2] шинжийг агуулдаг албадлагын өвөрмөц арга хэмжээг хэрэгжүүлдэг субьект юм.

Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэх явцдаа хорих байгууллага нь дээрх зорилтуудыг хангахаас гадна хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдогчдын болон ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, хоригдогчдын зүгээс хорих байгууллагад гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зэрэг аюулгүй байдлаа хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Өөрөөр хэлбэл цагдан хорих үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл нь аюулгүй байдлыг хангах асуудал байх бөгөөд энэ нь цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдогчдын болон ажилтан, албан хаагчдийн аюулгүй байдлыг хангах замаар Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад тодорхой үүрэг хүлээдэг төрийн тусгай алба болох нь харагдаж байна.

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.2002.www.legalinfo.mn/law/details/89
[2] Эрүүгийн байцаан шийтгэх хууль.2002. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002. №12

Хорих байгууллага нь хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчийг хорих, баривчлах[1], хоригдогчийн зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Зарим судлаачдын үзсэнээр “Цагдан хорих үйл ажиллагаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдийн болон нийгмийн аюулгүй байдлыг хангахад ч зохих үүргээ гүйцэтгэдэг"[2] болохыг онцолсон байдаг.

2002 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль’’ батлагдсанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэгт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа нэмэгдэн, нийслэл дэх цагдан хорих төв, орон нутаг дахь цагдан хорих байруудыг Цагдаагийн ерөнхий газрын харъяаллаас шилжүүлэн авч ажиллах болсон тэр үеэс эхлэн хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд цагдан хорих байрны тухай асуудал тавигдах болсон.

Улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт явдлын дийлэнх хувийг хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад шүүх, прокурорын байгууллагаас цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авах болсон нь хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэх зорилгоор цагдан хорьж болно”[3] гэсэн заалтыг үндэслэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг голлон хэрэглэж байгаа нь цагдан хоригдох этгээдийн тоог нэмэгдүүлж улмаар цагдан хорих байрны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн нэг болоод байна.

Улсын хэмжээнд цагдан хоригдсон этгээдийн тоон үзүүлэлтийг сүүлийн 5 жилийн байдлаас үзэхэд тасралтгүй өссөн дүн гарсан нь "удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт

[1] Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. 1999. Шүүхийи шийдвэр гүйцэтгэх ерөихий газар. Эрх зүйи баримт бичгийн эмхтгэл. УБ.,2014. 88-102 дахь тал.

[2] Н.Гантулга. Хүний эрх ба хорих ял. УБ., 2015. 194 дэх тал.

[3] Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002. №12.

хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг цагдан хорино”[1] гэсэн хуулийн заалттай холбоотойгоор хоригдогчдын тоо өссөн байх магадлалтай юм.

Хүснэгт 1: Цагдан хоригдогсдын тоон үзүүлэлт




Цагдан хоригдогчдын тоо нэмэгдсэнээр тэдэнд тавих хяналт сулрах, гэмт хэрэг зөрчил үйлдэгдэх, хоригдогчид биенээ дарамтлах, албан хаагчийн аюулгүй байдалд эрсдэл учрах, улмаар цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдлыг үүсгэж байна.

Цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэж буй харуул хамгаалалтын ажилтны тоо, хоригдож буй хоригдогсдын тооны харьцаа, ажлын ачаалалд дүн шинжилгээ хийж үзэхэд нэг өдөрт харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх албан хаагчдын тоо нь тухайн цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогсдын тооноос 10-20 дахин буюу 90% орчмоор бага байна. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын ажлын ачааллын жишиг норматив”-т 10 сэжигтэн тутамд 1 хянагч үүрэг гүйцэтгэнэ[1] [2] гэж заасан байх боловч Цагдан хорих төвд нэг хянагч 80-110 хоригдогчид хяналт тавин ажиллаж байгаа нь албан хаагчийн ажлын ачаалал 8-10 дахин нэмэгдсэн төдийгүй тэдний аюулгүй байдалд нөлөөлөх эрсдлийг нэмэгдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсад гарч байгаа гэмт явдлын судалгаанаас үзэхэд шинэ төрлийн, нийгмийн хор аюул бүхий гэмт хэргүүд үйлдэгдэх боллоо. Тухайлбал хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн, зарж борлуулсан, зохион байгуулалттай бүлэглэл, авлига албан тушаалын гэх мэт гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр цагдан хоригдогсдын тоо нэмэгдэж байгаа нь цагдан хорих байрны дотоод журмыг зөрчих, хоригдогсдын дунд гэмт хэрэг, зөрчил гаргах явдлыг өдөөх, албан хаагчдад

[1] Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002

[2] Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2008 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 205/94 тоот хамтарсан тушаал.

сөргөөр нөлөөлөхийг оролдох гэх мэт ноцтой аюулыг бий болгох байдал ажиглагдах болсон.

Манай улсад хар тамхи мансууруулах бодисын хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь 2015 онд Хууль зүйн яам, ‘"Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллагатай хамтран хийсэн судалгаагаар 16 мянга гаруй хэрэглэгч байна гэсэн дүн гарсан нь хар тамхи мансууруулах бодисын хэрэглээ 1999 оноос хойш 10 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнтэй холбоотойгоор хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэж, 2015 онд 79 гэмт хэрэгт 169 хүн сэжигтэнээр татагдан шалгагджээ[1].

Цагдан хорих 461 дүгээр ангид 2015 онд хар тамхи мансууруулах бодис хэрэглэсэн, дамжуулсан, зарж борлуулсан гэмт хэрэгт 82 этгээд холбогдон цагдан хоригджээ[2]. Эдгээр хоригдогчид нь хар тамхи мансууруулах бодистой хамааралтай. донтсон, зарж борлуулдаг, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүн байж болзошгүй этгээдүүд хоригдож байгаа нь цагдан хорих байр руу хар тамхи, мансууруулах бодис нууцаар нэвтрүүлэн хэрэглэж болзошгүй аюул занал бодитойгоор тулгарч байна гэж үзэж болно.

Учир нь хар тамхи маш олон төрөлтэй бөгөөд эдгээр нь жижиг хэмжээтэй, гадна төрхийг нь хувирган энгийн хүний нүдээр харахад таньж мэдэхээргүй болгосон нь хоригдогчид биедээ болон бусад эд зүйлс дотор нууж цагдан хорих байр руу нэвтрүүлэн хэрэглэж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна.

Цагдан хоригдсон этгээд нь мансуурсан тохиолдолд бусад хоригдогчдын амь биед халдах, гэмт хэрэг үйлдэх, албан хаагчдын биед халдах зэрэг сөрөг нөхцөл байдал үүсгэж болзошгүй байгаа тул цагдан хорих төвд хар тамхи нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн төрлийн бодисыг илрүүлэх рентген багаж хэрэгсэлтэй болгох, мөн энэ чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх нь зайлшгүй шаардлагатай юм.

Мөн хоригдогчдийн зүгээс албан хаагчдын тавьсан шаардлагыг эсэргүүцэх, биелүүлэхгүй байх, биед нь халдах зэрэг зөрчил өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдэх хандлагатай байна. Нийслэл дэх цагдан хорих төвд 2016 оны эхний 10 дүгээр сарын байдлаар албан хаагчдын биед халдан гэмтэл учруулсан 5, албан хаагчийн хууль ёсны шаардлагыг

[1]Цагдаагийн ерөнхий газар. Статистик мэдээ. 2016.
[2] Цагдан хорих 461 дүгээр ангийн тоо бүртгэлийн тайлан. 2015

биелүүлээгүй, эсэргүүцсэн 12, жижгээр танхайрсан 14 гэсэн зөрчил үйлдэгдсэн байх ба үүнд албан тушаалаар нь авч үзвэл хянагч бүрэлдэхүүн халдлагад өртсөн нь албан хаагчдын хувийн аюулгүй байдал алдагдсан болохыг харуулж байна. Цагдан хорих байранд дээрх төрлийн зөрчил гарах болсон нь сэжигтэн, яллагдагчид хүлээлгэх хариуцлага эрх зүйн хувьд зохицуулаагүй, сахилгын арга хэмжээний үр нөлөө бага байгаатай шууд холбоотой гэж дүгнэж болно.

Зөрчил гаргасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид “Сэжигтэн, яллагдагчийн баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль"-ийн 34 дүгээр зүйлд заасны дагуу “....7-15 хоног сахилгын байранд хорино” гэсэн заалтын хүрээнд сахилгын шийтгэл оногдуулж байгаа нь сахилгын шийтгэлийн үр нөлөө бага буюу нэг өрөөнөөс нөгөө өрөөнд шилжүүлэн байршуулж, хорих өрөөтэй нэгэн адил нөхцөлд сахилгын шийтгэлийг эдлүүлж байгаа нь хоригдогчийн зүгээс үйлдэгдэх зөрчил буурахгүй байх нэг шалтгаан болж байна.

Иймд цагдан хоригдох хугацаандаа гаргасан зөрчлийг хорих байрны ажилтан /төлөөлөгч/ баримтжуулан, шалгасан материалыг таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эрүүгийн хэрэгт хавсарган өгөх нь тухайн хоригдогчийн хувийн зан байдал, гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулсан эсэх нь харагдах, мөн цагдан хоригдох үедээ зөрчил гаргахгүй байх хөшүүрэг болж өгөх зэрэг ач холбогдолтой байж болох юм.

Сүүлийн жилүүдэд төрийн өндөр дээд албан тушаал хашиж байсан болон бизнесийн бүлэглэлийн этгээдүүд хоригдох болсон нь цагдан хорих байрны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж эхэлсэн. Учир нь эдгээр хоригдогчид нь гадагш /гэр бүл, гэмт хэрэг хамтран үйлдэгч гэх мэт/ харилцаа холбоо тогтоолгох, хориотой эд зүйлс дамжуулан авах, бусад хоригдогчдоос давуу байдал олж авах зорилгоор албан хаагчдад мөнгө, эд зүйл амлах, бусдаар дамжуулан өгөх зэргээр өөрийн эрхшээлдээ оруулахыг идэвхтэй эрмэлзэх болсон. Мөн эдгээр хоригдогчид нь байгууллагын дотоод үйл ажиллагааны талаар буруу ташаа мэдээллийг олон нийтэд зориудаар тараах зэргээр цагдан хорих байрны аюулгүй байдалд нөлөөлөхүйц үйл ажиллагааг явуулах болсон нь ажиглагдаж байна.Цагдан хорих байрны аюулгүй байдалд тулгамдаж буй дээрх асуудлуудаас үүдэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдан хоригдогсдын тоо нэмэгдэх болсон нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-нд удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол цагдан хорино гэсэн заалттай холбоотойгоор цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг

прокурор, шүүхийн байгууллага хэрэглэж байна. Цагдан хоригдогсдын тоо нэмэгдсэнээр хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа, хоригдогч болон ажилтан, албан хаагчдын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэчлэсэн найруулгад энэ зүйл заалтад өөрчлөлт оруулах;

2. Цагдан хоригдсон этгээдүүд нь шалгагдаж буй гэмт хэргээс шалтгаалан сэтгэл зүйн хувьд тогтворгүй байдаг онцлогтой тул амиа хорлохыг завдах, уур бухимдалаа албан хаагчдад гаргаж хэл амаар доромжлох, биед нь халдах зэрэг гэмт хэрэг, зөрчлүүд үйлдэж байгаа нь хоригдогчид хүлээлгэх сахилгын хариуцлага сул, үр нөлөө бага байгаатай шууд холбоотой байна. Иймд хоригдогчийн цагдан хоригдох хугацаандаа гаргасан зөрчлийг хорих байрны ажилтан /төлөөлөгч/ баримтжуулан шалгасан материалыг нь таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эрүүгийн хэрэгт хавсарган өгөх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3. Манай улсад хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж улмаар гэмт хэрэгт холбогдон хоригдох болсон нь цагдан хорих байруудын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал бий болжээ. Иймээс цагдан хорих байруудад хар тамхины төрлийн бэлтмэлийг илрүүлэх техник хэрэглсээр хангах, албан хаагчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэн сургах зайлшгүй шаардлага тулгарч байна.

***Б.Гантулга** - Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, хошууч*

## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШИГ УЧИРСАН ҮЕД ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

***Товч агуулга:** Энхүү судалгааны ажлаар өнөө үед хорих байгууллагад тулгамдаад буй газар хөдлөлтөөс улбаалсан гамшигын үед байгууллагын удирдлагад учирдаг хүндрэл бэршээлүүдийг судлан хэрэхэн шийдвэр гаргах, урдчилан сэргийлэх арга хэмжээнг яаж авах талаар авч үзэн цаашид хэрхэх талаар санал дүгнэлт хүргэхийг зорилоо.*

***Түлхүүр** үг. Хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа, газар хөдлөл, удирдлагын шийдвэр гаргалт*

Өнөө үед дэлхий дээр тохиолдож буй аюулт үзэгдэл, гамшгийн тоо харьцангуй нэмэгдэж, түүнээс учрах хор уршигийн үр дагавар улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд энэхүү аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудлыг улс орон бүр хандлага, үндэсний аюулгүй байдал, хөгжлийн бодлого, стратегийн бодлоготой хамааруулан авч үзэх цаг болсон байна.